

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн ХАМТАРСАН МЭДЭЭЛЭЛ

Өмнөговь аймаг
Ханбогд сум

Иргэдийн хөгжлийн төв
2016 оны 08-р сарын 18

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн ээлжит хурал 2016 оны 08 дугаар сарын 18-ны өдөр Иргэдийн хөгжлийн төвд боллоо. Хуралд Ханбогд сумын Захиргааны төлөөлөл, Малчидын төлөөлөл, ОТ ХХК-ийн төлөөлөл оролцож, Эрх зүйн нийцэл хяналт, зөвлөгөө, омбудсмений газрын (ЭЗХЗОГ) чиглүүлэгч нар хурлыг чиглүүлж зөвлөж ажиллав. Мөн ОТ компанийн байгаль орчины хариуцсан ерөнхий менежер болон Ханбогд сумын Жавхлант, Баян, Гавилууд багийн долоон малчид Зөвлөлийн хуралд ажиглагчаар оролцсон болно.

Тус хурлаар Зөвлөлийн өмнөх хурлуудаар хэлэлцэж тохирсон ажлын хэрэгжилтийн явцыг хэлэлцлээ. Тухайлбал, 2016 онд Зөвлөлийн хүрээнд хэрэгжүүлж буй гол ажлуудын нэг нь Олон талт мэргэжлийн шинжээчдийн баг болон Хөндлөнгийн шинжээчдийн багийн судалгааны ажил байдаг. Эдгээр багуудын хэрэгжүүлж буй Ханбогд сумын малчин өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа, Ундай голын гольдрол өөрчлөлтийн улмаас үүссэн хам нөлөөллийн 2-р шатны судалгааны гурав дах удаагийн явцын тайлантай Зөвлөлийн гишүүд танилцаж, саналаа өгөв.

Мөн Зөвлөлийн 2 удаагийн өргөтгөсөн хурлаас малчид иргэдийн гаргасан хүсэлт, шаардлагыг энэ оны 6-р сарын хурлаар хэлэлцсэн бөгөөд Оюу Толгой ХХК-ны санал болгосноор хийхээр тохирсон ажлын дагуу гоожиж буй цооног битүүмжлэх ажлыг гүйцэтгэх ОТ-н гэрээлэгч компани Эрдэнэ Дриллинг компанийн захирал Б.Шихтулга ирж битүүмжлэх аргачлалаа танилцуулж ГТЗ-ийн гишүүд болон ажиглагч малчдын асуултанд хариулав. Битүүмжлэх ажилтай ГТЗ, малчдын төлөөллийг зохион байгуулж танилцуулахаар болов.

2015 оны 3 дугаар сард баталсан Ус зөөх түр журмыг хэлэлцэв. Уг журмын дагуу Оюу толгой ХХК нь уурхайн талбайгаас 20 км-н тойрог дотор нутагладаг малчдын худгийн усны нөөц муудсан үед уурхайн талбайгаас мал услах зориулалттай ус (ундны ус биш) зөөвөрлөн хүргэх ажлыг хариуцан зохион байгуулж ирсэн билээ. Зөвлөлийн хурлаар уг журмыг хэлэлцээд, дараах нэмэлт өөрчлөлтийг оруулав. Үүнд: 1) Бэлчээрийг хуваарьтай ашиглах болон улирлын нутаглалт зохицуулах зорилгоор 7-р сарын 1-ээс 11-р сарын 30-ны хооронд болон зунжааны нутагт ус зөөвөрлөн хүргэх ажлыг хийхгүй байх, 2) ойролцоо нутагладаг болон өвөлжөө эзэмшдэг, бэлчээр хамтран ашигладаг бусад малчдын баталгаажилтыг Гурван талт зөвлөлд тухайн багийн малчдыг төлөөлөн сууж буй төлөөлөгч эцэслэн баталгаажуулахаар боллоо.

Зөвлөлийн үйл ажиллагааны тухай мэдээллийг Ханбогд сумын олон нийтэд хүргэх хэрэгцээ шаардлагыг хангах үүднээс Мэдээллийн багтай боллоо. Мэдээллийн багт гурван талын нэг нэг төлөөллийг сонгож, журам боловсруулан ажиллахаар тохирлоо.

Ханбогд сумын Гурван талт зөвлөл

Гурван Талт Зөвлөлийн тухай

Ханбогд сумын Сумын удирдлага, Малчдын төлөөлөгчид болон Оюу толгой компанийн хамтарсан Гурван талт зөвлөл (ГТЗ) нь талуудын маргааныг шийдвэрлэх зорилгоор Харилцан ойлголцлын санамж бичигт зурсны дагуу 2015 оны 6 сарын 8-нд албан ёсоор байгуулагдсан болно. ГТЗ-ийн үйл ажиллагааг Эрх зүйн нийцэл хяналт, зөвлөгөө, омбудсмений газраас (ЭЗХЗОГ) чиглүүлж байна. ЭЗХЗОГ бол Дэлхийн банкны группын Олон улсын санхүүгийн корпорацид чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг хараат бус байгууллага болно.